



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 2/436

Улаанбаатар хот

**Д.Нямсүрэнгийн туршилтын хугацааг
дуусгавар болгон албан тушаалд
томилох тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Төрийн албаны тухай хуулийн 27.1.3 дахь заалт, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 472 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2021 оны 83 дугаар тогтоол, Авлигатай тэмцэх газрын 2019 оны 05/770 тоот албан бичгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Дондийгийн Нямсүрэнгийн туршилтын хугацааг 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрөөр дуусгавар болгон үүрэгт ажлаас чөлөөлж, мөн өдрөөс Дундговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн хяналтын улсын байцаагчаар томилсугай.

2.Д.Нямсүрэнд 37 дугаартай хяналтын улсын байцаагчийн тэмдэг хэрэглэхийг зөвшөөрсүгэй.

3.Д.Нямсүрэнгийн иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд нэвтрэх эрхийг нээхийг Иргэний улсын бүртгэлийн газар /Т.Нармандах/, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд нэвтрэх эрхийг нээхийг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар /Б.Ариунболд/, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд нэвтрэх эрхийг нээхийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар /Т.Төгөлдөр/-т тус тус даалгасугай.

4.Албаны нууцтай танилцах эрх олгон, төрийн болон албаны нууц задруулахгүй байх баталгааг гаргуулж, холбогдох хууль тогтоомжийг танилцуулахыг нууц хамгаалах ажилтан /Ж.Өлзийжаргал/-д үүрэг болгосугай.

5.Д.Нямсүрэнгийн албан тушаалын цалинг төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээний ТЗ-7-3-д хамааруулж, зэрэг дэвийн нэмэгдлийг 18, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 10 хувиар, хоол унааны нөхөх зардлыг холбогдох журмын дагуу тус тус тооцон олгохыг Дундговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс /Ж.Өлзийжаргал/-т зөвшөөрсүгэй.

6.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

571004589